



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.1.5 заалт, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн төсөл”-ийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банкны 28,588,400.00 (хорин найман сая таван зуун наян найман мянга дөрвөн зуун) ам.долларын зээлийн санхүүжилтээр бий болсон хавсралтад заасан хөрөнгө, өр төлбөрийг Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу ашиглаж эхэлсэн хугацаанаас хойших холбогдох зардлыг тооцож “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Артур, гүйцэтгэх захирал Р.Батсүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Зээлийн хөрөнгөөр бий болж 2020 онд ашиглалтад орсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн техникийн бичиг баримт, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийг баталгаажуулсан санхүүгийн бичиг баримтыг бүрдүүлэх;

2.2.Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-н үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201107

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 03 дугаар сарын 09-ний
өдрийн 52 дугаар тогтоолын хавсралт

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн балансад бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	хэмж их нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (ам.доллар)	Хөрөнгийн үнэ (ам.доллар)
1	DC32IV-1520 маркийн чигжигч машин	ш	2	2,824,000.00	5,648,000.0
2	WD350-1520 маркийн замын динамик тогтворжуулагч	ш	2	2,472,000.00	4,944,000.0
3	QS2-650-1520 маркийн балласт цэвэрлэгч машин	ш	1	6,227,400.00	6,227,400.0
4	SPZ-350-1520 маркийн балласт тохируудагч	ш	2	1,520,000.00	3,040,000.0
5	KZ75-1520 маркийн балатст хоппер вагон	ш	57	140,000.00	7,980,000.0
6	GCY220-1520 маркийн засварын мотовоз	ш	1	749,000.00	749,000.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН динамик тогтворжуулагч		65 (жаран тав)		28,588,400.00 (хорин найман сая таван зуун наян найман мянга дөрвөн зуун)